



Тус ханог тутмын хэвлэл
2009 оны 11 дүгээр сарын 11
№42 /615/

“ШПЛААГ”

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Монгол Улсын хууль

856

Монгол Улсын Их
Хурлын тогтоол

857

Монгол Улсын
Засгийн газрын
тогтоол

883

Улаанбаатар хот
2009 он

**Нэмэгдсэн өртгийн албан
татвараас чөлөөлөх тухай**

**Төр, хувийн хэвшлийн
түншлэлийн талаар төрөөс
баримтлах бодлого батлах
тухай**

**Улсын төсөвт үйлдвэрийн газар
байгуулах тухай**

Улсын Их Хурлын Тамгын Газар

**ГАРЧИГ****МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

- | | | |
|------|---|-----|
| 538. | Ашигт малтмалын тухай хуулийн зарим хэсгийг хүчингүй болсонд тооцох тухай | 856 |
| 539. | Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай | 856 |
| 540. | Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай | 857 |

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

- | | | | |
|------|--|-----------|-----|
| 541. | Төр, хувийн хэвшлийн түншлэлийн талаар төрөөс баримтлах бодлого батлах тухай | Дугаар 64 | 857 |
| 542. | С.Баярыг Монгол Улсын Ерөнхий сайдын албан тушаалаас чөлөөлөх тухай | Дугаар 67 | 863 |
| 543. | Монгол Улсын Ерөнхий сайдыг томилох тухай | Дугаар 68 | 864 |
| 544. | Засгийн газрын гишүүн, Гадаад харилцааны сайдын албан тушаалаас чөлөөлөх тухай | Дугаар 69 | 864 |

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

- | | | | |
|------|--|------------|-----|
| 545. | Зарим хүнийг одон, медалиар шагнах тухай | Дугаар 127 | 865 |
|------|--|------------|-----|

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

- | | | | |
|------|--|------------|-----|
| 546. | Тогтоолд өөрчлөлт оруулах тухай | Дугаар 205 | 865 |
| 547. | Төлөвлөгөө батлах тухай | Дугаар 208 | 866 |
| 548. | Дайнд оролцсон ахмад дайчинд орон сууц олгох тухай | Дугаар 212 | 882 |
| 549. | Улсын төсөвт үйлдвэрийн газар байгуулах тухай | Дугаар 213 | 883 |

МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ

- | | | | |
|------|---|-----------|-----|
| 550. | Эрүүгийн хуулийн 28 дугаар бүлгийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай | Дугаар 23 | 884 |
|------|---|-----------|-----|

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2009 оны 10 дугаар
сарын 15-ны өдөр

Улаанбаатар
хот

Ашигт малтмалын тухай хуулийн зарим хэсгийг хүчингүй болсонд тооцох тухай

1 дүгээр зүйл. Ашигт малтмалын тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.4 дэх хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2010 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2009 оны 10 дугаар
сарын 30-ны өдөр

Улаанбаатар
хот

Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай

1 дүгээр зүйл. Томуугийн А хүрээний /H1N1/ вирусын халдварын оношлогоо, эмчилгээнд хэрэглэх оношлуур, эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, ариутгал, халдваргүйжүүлэлтийн бодисыг импортоор оруулахад нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийн 1 дүгээр зүйлд заасан эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, ариутгал, халдваргүйжүүлэлтийн бодисын жагсаалтыг Засгийн газар батална.

3 дугаар зүйл. Энэ хуулийг 2009 оны 10 дугаар сарын 30-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2009 оны 10 дугаар
сарын 30-ны өдөр

Улаанбаатар
хот

Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай

1 дүгээр зүйл. Томуугийн А хүрээний /H1N1/ вирусын халдварын оношлогоо, эмчилгээнд хэрэглэх оношлуур, эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, ариутгал, халдваргүйжүүлэлтийн бодисыг импортоор оруулахад гаалийн албан татвараас чөлөөлсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийн 1 дүгээр зүйлд заасан эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, ариутгал, халдваргүйжүүлэлтийн бодисын жагсаалтыг Засгийн газар батална.

3 дугаар зүйл. Энэ хуулийг 2009 оны 10 дугаар сарын 30-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2009 оны 10 дугаар
сарын 15-ны өдөр

Дугаар 64

Улаанбаатар
хот

Төр, хувийн хэвшлийн түншлэлийн талаар төрөөс баримтлах бодлого батлах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. "Төр, хувийн хэвшлийн түншлэлийн талаар төрөөс баримтлах бодлого"-ыг хавсралтаар баталсугай.

2. "Төр, хувийн хэвшлийн түншлэлийн талаар төрөөс баримтлах бодлого"-ыг баталсантай холбогдуулан дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Засгийн газар /С.Баяр/-т даалгасугай:

1/Төр, хувийн хэвшлийн түншлэлийн талаар төрөөс баримтлах бодлого"-ыг үе шаттайгаар хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 2010 оны 1 дүгээр улиралд багтаан батлах;

2/Төр, хувийн хэвшлийн түншлэлийн талаар төрөөс баримтлах бодлого"-ыг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг жил бүрийн Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл болон улсын төсөвт тусган хэрэгжүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо /Ц.Баярсайхан/-нд даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ



Монгол Улсын Их Хурлын 2009 оны
64 дүгээр тогтоолын хавсралт

**ТӨР, ХУВИЙН ХЭВШЛИЙН ТҮНШЛЭЛИЙН ТАЛААР
ТӨРӨӨС БАРИМТЛАХ БОДЛОГО**

Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогод тусгагдсан хувийн хэвшил тэргүүлсэн эдийн засгийн эрчимтэй өсөлтийг хангах, бүх талын түншлэлийг хөхиүлэн дэмжих замаар Монгол Улсын эдийн засгийг тогтвортой хөгжүүлэхэд түлхэц болоход энэхүү бодлогын зорилго оршино.

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Төр, хувийн хэвшлийн түншлэл /цаашид "түншлэл" гэх/ийн талаар баримтлах бодлого нь Монгол Улсад сайн засаглалыг бэхжүүлэх, дэлхийн эдийн засгийн түгээмэл хандлага, өөрийн орны өвөрмөц онцлогт нийцсэн олон хэвшил бүхий эдийн засгийг хөгжүүлэх Монгол Улсын төрийн бодлогын салшгүй хэсэг байна.

1.2. Түншлэлийн талаар төрөөс баримтлах бодлого /цаашид "бодлого" гэх/ нь дэд бүтцийн болон нийгмийн суурь үйлчилгээг нийтэд үзүүлэх, Засгийн газраас тэргүүлэх ач холбогдол өгч байгаа төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд төр, хувийн хэвшил хамтран ажиллах, төрийн тодорхой чиг үүргийг хувийн хэвшлийн этгээдээр гүйцэтгүүлэх замаар эдгээр салбар дахь төрийн оролцоог оновчтой болгох, суурь үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, төсвийн үр ашгийг дээшлүүлэхэд чиглэнэ.

1.3. Бодлогын зорилт нь:

1.3.1. хувийн хэвшил тэргүүлсэн эдийн засгийн эрчимтэй өсөлтийг хангах;

1.3.2. дэд бүтцийн болон нийгмийн суурь үйлчилгээний салбарт хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг татах, нэгдсэн төсвийн үр ашгийг дээшлүүлэх, хувийн хэвшлийн үйл ажиллагааг дэмжсэн эрх зүйн таатай орчныг бүрдүүлэх;

1.3.3. дэд бүтцийн болон нийгмийн суурь үйлчилгээний салбарт хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлж, чанар, хүртээмжийг сайжруулах замаар түншлэл, итгэлцэл, хамтын ажиллагааг бэхжүүлэхэд оршино.

1.4. Бодлогыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

Хоёр. Бодлогын зарчим, төрөл, чиглэл

2.1. Бодлогыг тодорхойлох, хэрэгжүүлэхдээ дараахь зарчмыг баримтална:

2.1.1. эдийн засгийн өсөлтийг оновчтой удирдлагаар хангах;

2.1.2. олон нийтийн эрх ашигт нийцсэн байх;

2.1.3. төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, үр ашигтай байх;



- 2.1.4. шударга ёс, хууль дээдлэх;
- 2.1.5. ил тод, нээлттэй байдлыг хангасан байх;
- 2.1.6. үндэсний аюулгүй байдалд харшлахгүй байх;
- 2.1.7. байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх;
- 2.1.8. хувийн хэвшлээс хөрөнгө оруулах, түншлэх сонирхлыг татахуйц байх;

2.1.9. түншлэлийн төсөд, арга хэмжээний үр дүн нь үйл ажиллагаанд зарцуулсан өртгөөс дутуугүй байх.

2.2. Үйлчилгээний чанар, хүртээмж, технологи, үйл ажиллагаа, удирдлагын тогтолцоо түншлэлийн өмнөх түвшинээс сайжирч, тухайн ажил, үйлчилгээг үзүүлэхтэй холбоотой төсөвт үзүүлэх дарамт буурсан байна.

2.3. Түншлэлд оролцогч хувийн хэвшлийн этгээдийг хуульд тусгайлан зааснаас бусад тохиолдолд сонгон шалгаруулалтын үндсэн дээр сонгоно.

2.4. Түншлэлийн арга, хэлбэр, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөө, холбогдох төрийн байгууллагаас гаргасан шийдвэр, хувийн хэвшлийн этгээдийг сонгон шалгаруулах ажиллагаа, түншлэлийн үр дүн нийтэд ил тод, нээлттэй байна.

2.5. Үндэсний компаниудын түншлэлд оролцох бололцоог тэргүүн ээлжинд дэмжих замаар тэдгээрийг санхүү, боловсон хүчнээр бэхжүүлэх, шинэ техник, технологиор хангах бодлого баримтална.

2.6. Бодлого нь бүс нутаг, орон нутгийн хөгжлийг эрчимжүүлэхэд чиглэнэ.

Гурав. Бодлогыг хэрэгжүүлэх үе шат

3.1. Бодлогыг дараахь үе шаттайгаар хэрэгжүүлнэ:

3.1.1. түншлэлийн талаар баримтлах төрийн бодлогыг тодорхойлох;

3.1.2. түншлэлийн эрх зүйн таатай орчныг бүрдүүлэх;

3.1.3. төрийн зарим ажил, үйлчилгээг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх үндэс суурийг тавьж, бэхжүүлэх;

3.1.4. хувийн хэвшлээс төрийн зарим ажил, үйлчилгээг гүйцэтгэх үйл ажиллагаанд оруулах хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхийг хөхиүлэн дэмжих;

3.1.5. түншлэлийг тогтвортой болгох.

Дөрөв. Бодлогыг хэрэгжүүлэх арга зам, хэлбэр

4.1. Түншлэл нь дараахь төрөлтэй байна:

4.1.1. нийгмийн салбарын түншлэл;

4.1.2. дэд бүтцийн салбарын түншлэл;

4.1.3. төрийн тодорхой чиг үүргийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх түншлэл;

4.1.4. үндэсний болон бүс нутгийн хэмжээний томоохон



төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх түншлэл;

4.1.5. байгаль орчны салбарын түншлэл.

4.2. Энэ бодлогын 4.1.1-д заасан нийгмийн салбарын түншлэлд дараахь асуудал хамаарна:

4.2.1. эрүүл мэнд;

4.2.2. боловсрол;

4.2.3. соёл урлаг;

4.2.4. шинжлэх ухаан;

4.2.5. бусад.

4.3. Энэ бодлогын 4.1.2-т заасан дэд бүтцийн салбарын түншлэлд дараахь асуудал хамаарна:

4.3.1. эрчим хүч, сэргээгдэх эрчим хүч;

4.3.2. дулаан дамжуулах болон түгээх сүлжээ;

4.3.3. мэдээлэл, харилцаа холбоо;

4.3.4. усан хангамж, ариутгах татуурга;

4.3.5. нийтийн тээвэр;

4.3.6. авто зам;

4.3.7. орон сууц;

4.3.8. бусад.

4.4. Энэ бодлогын 4.1.5-д заасан байгаль орчны салбарын түншлэлд дараахь асуудал хамаарна:

4.4.1. эколог;

4.4.2. хог хаягдлын удирдлага.

4.5. Түншлэлийн хүрээнд хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийн жагсаалтыг Засгийн газар батална.

4.6. Төрийн, эсхүл аймаг, нийслэлийн өмч, эд хөрөнгийг концессын гэрээний үндсэн дээр эзэмшүүлэх, ашиглуулах, шинээр бий болгоход дараахь аргыг ашиглана:

4.6.1. "Барих-ашиглах-шилжүүлэх" (BOT) - эрх эзэмшигч гэрээний зүйл болох байгууламжийг өөрийн болон өөрийн боломжоор олсон хөрөнгөөр барьж, ашиглалтад оруулан гэрээнд заасан хугацааны дотор ашиглан, хугацаа дуусгавар болсон тохиолдолд гэрээнд заасан нөхцөлийн дагуу эрх бүхий этгээдийн өмчлөлд шилжүүлэн өгөх үүрэг хүлээх;

4.6.2. "Барих-шилжүүлэх" (BT) - эрх эзэмшигч нь гэрээний зүйл болох байгууламжийг өөрийн болон өөрийн боломжоор олсон хөрөнгөөр барьж, ашиглалтад оруулан гэрээнд заасан нөхцөл бүрдсэн тохиолдолд эрх бүхий этгээдийн өмчлөлд шилжүүлэх;

4.6.3. "Барих-өмчлөх-ашиглах" (BOO) - эрх эзэмшигч гэрээний зүйл болох байгууламжийг өөрийн болон өөрийн боломжоор олсон хөрөнгөөр барьж, ашиглалтад оруулан, гэрээнд заасан нөхцөлийн дагуу өмчлөн, ашиглах эрх эдэлж, үүрэг хүлээх;



4.6.4. "Барих-өмчлөх-ашиглах-шилжүүлэх" (BOOT) - энэ аргын зохицуулалт нь энэ бодлогын 4.6.1-д заасан BOT-той төстэй боловч, гэрээний зүйл болох байгууламжийг гэрээнд заасан хугацаанаас өмнө эрх бүхий этгээдийн өмчлөлд шилжүүлэх асуудал үүсэхгүй;

4.6.5. "Барих-түрээслэх-шилжүүлэх (BLT) - эрх эзэмшигч гэрээний зүйл болох байгууламжийг өөрийн болон өөрийн боломжоор олсон хөрөнгөөр барьж, ашиглалтад оруулан улмаар гэрээнд заасан нөхцөлийн дагуу эрх бүхий этгээдэд санхүүгийн түрээсээр эзэмшүүлэх, түрээсийн хугацаа дуусмагц эрх бүхий этгээдийн өмчлөлд шилжүүлэх үүрэг хүлээх;

4.6.6. "Зураг төсөл боловсруулах-барих-санхүүжүүлэх-ашиглах" (DBFO) - эрх эзэмшигч гэрээний зүйл болох байгууламжийн зураг төслийг боловсруулж, өөрийн болон өөрийн боломжоор олсон хөрөнгөөр барьж, гэрээнд заасан хугацаанд ашиглан, хугацаа дуусгавар болоход гэрээнд заасан нөхцөлийн дагуу эрх бүхий этгээдийн өмчлөлд шилжүүлэн өгөх үүрэг хүлээх.

4.7. Концессын гэрээ байгуулагч талууд тухайн төслийг хэрэгжүүлэхэд тохирсон энэ зүйлд зааснаас бусад аргыг сонгож болно.

Тав. Түншлэлийн талууд

5.1. Дараахь төрийн байгууллага түншлэлд оролцоно:

- 5.1.1. Монгол Улсын Засгийн газар;
- 5.1.2. Монгол Улсын яам;
- 5.1.3. Засгийн газрын агентлаг;
- 5.1.4. аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал;
- 5.1.5. аймаг, нийслэлийн Засаг дарга, түүний Тамгын газар;
- 5.1.6. төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд.

5.2. Түншлэлд хувийн хэвшлийг төлөөлж дараахь этгээд оролцоно:

- 5.2.1. компани;
- 5.2.2. нөхөрлөл, хоршоо;
- 5.2.3. төрийн бус байгууллага;
- 5.2.4. хувь хүн.

5.3. Түншлэл дараахь хэлбэртэй байна:

- 5.3.1. гэрээний үндсэн дээр төрийн байгууллагад ажил, үйлчилгээ үзүүлэх;
- 5.3.2. төрөөс үзүүлэх тодорхой үйлчилгээг гэрээний үндсэн дээр хэрэгжүүлэх;
- 5.3.3. төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдлага, үйл ажиллагааг гэрээний үндсэн дээр хэрэгжүүлэх;



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2009 оны 10 дугаар
сарын 29-ний өдөр

Дугаар 68

Улаанбаатар
хот

Монгол Улсын Ерөнхий сайдыг томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 4 дүгээр зүйл, 21 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, санал хураалтын дүнг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Ерөнхий сайдаар Сүхбаатарын Батболдыг томилсугай.
2. Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүний тухай саналаа Монгол Улсын Үндсэн хууль болон холбогдох хуулийн дагуу шийдвэрлүүлэхийг Монгол Улсын Ерөнхий сайд /С.Батболд/-д даалгасугай.
3. Энэ тогтоолыг 2009 оны 10 дугаар сарын 29-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2009 оны 10 дугаар
сарын 29-ний өдөр

Дугаар 69

Улаанбаатар
хот

Засгийн газрын гишүүн, Гадаад харилцааны сайдын албан тушаалаас чөлөөлөх тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Ерөнхий сайдаар томилогдсонтой холбогдуулан Сүхбаатарын Батболдыг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Гадаад харилцааны сайдын албан тушаалаас чөлөөлсүгэй.
2. Энэ тогтоолыг 2009 оны 10 дугаар сарын 29-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ**2009 оны 10 дугаар
сарын 01-ний өдөр

Дугаар 127

Улаанбаатар
хот**Зарим хүнийг одон, медалиар
шагнах тухай**

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн арван тавдугаар зүйлийн нэгийг үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ НЬ:

Монгол Улс, БНХАУ-ын хооронд дипломат харилцаа тогтоосны 60 жилийн ойг тохиолдуулан Монгол Улс, ӨМӨЗО-ны хоорондын харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэхэд оруулсан хувь нэмрийг нь үнэлж дор дурдсан хүмүүсийг одон, медалиар шагнасугай.

“АЛТАН ГАДАС” ОДОНГООР:

1. Өлзийбаярын Тогтох - БНХАУ-ын ӨМӨЗО-ны Жирэм аймгийн Өлзийт сумын иргэн
2. Баатар - БНХАУ-ын ӨМӨЗО-ны тэргүүлэгч
3. Тэмцэл - БНХАУ-ын ӨМӨЗО-ны Хөх хотын Хятад, Монгол эмнэлгийн эрхлэгч
4. Зян Вэй - БНХАУ-ын ӨМӨЗО-ны Гадаад хэрэг эрхлэх газрын дарга

“НАЙРАМДАЛ” МЕДАЛИАР:

1. Бү Сяолин - БНХАУ-ын ӨМӨЗО-ны дэд тэргүүлэгч
2. Чингэлтэй - БНХАУ-ын ӨМӨЗО-ны Өвөрмонголын Их сургуулийн профессор
3. Бао Юйхай - БНХАУ-ын ӨМӨЗО-ны Багшийн их сургуулийн орлогч захирал

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ****Ц.ЭЛБЭГДОРЖ****МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ**2009 оны 7 дугаар
сарын 08-ны өдөр

Дугаар 205

Улаанбаатар
хот**Тогтоолд өөрчлөлт оруулах тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 3-т заасныг үндэслэн Улсын Их Хурлын 2002 оны 52 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Батлан хамгаалах яамны эзэмшилд байгаа Нийслэлийн Налайх дүүргийн 5 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрладаг угсармал орон сууцны каркас байдалтай байгаа 5, 7, 8 гэсэн дугаартай барилгуудыг үнэлгээний байгууллагаар үнэлүүлж, сонгон авсан сонирхогч байгууллага, аж ахуйн

нэгжүүдтэй хамтран хөрөнгө оруулалт хийж засварлах, яаманд ногдох хөрөнгийн хэмжээнд нийцүүлэн тодорхой тооны орон сууцыг цэргийн албан хаагчдын хэрэгцээнд ашиглахыг Батлан хамгаалахын сайд Л.Болдод зөвшөөрсүгэй.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Хувьчлалд үл хамаарах орон сууцны жагсаалт батлах тухай" Засгийн газрын 1998 оны 8 дугаар сарын 18-ны өдрийн 148 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын 56-62 дахь хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

С.БАЯР

БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД

Л.БОЛД

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2009 оны 7 дугаар
сарын 08-ны өдөр

Дугаар 208

Улаанбаатар
хот

Төлөвлөгөө батлах тухай

Улсын Их Хурлын 2009 оны 39 дүгээр тогтоолыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Төрөөс малчдын талаар баримтлах бодлогын эхний үе шат (2009-2015 он)-нд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хавсралт ёсоор баталсугай.

2. Төлөвлөгөөнд заасан арга хэмжээ, санхүүгийн эх үүсвэрийг жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх Үндсэн чиглэл, улсын болон орон нутгийн төсөвт тусган санхүүжүүлж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Т.Бадамжунай, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Т.Ганди, Эрүүл мэндийн сайд С.Ламбаа, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд Е.Отгонбаяр, Сангийн сайд С.Баярцогт, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Төлөвлөгөөний хэрэгжилтийн явц, дүнг жил бүрийн I улиралд Засгийн газарт танилцуулж байхыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Т.Бадамжунай үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

С.БАЯР

**ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН
ҮЙЛДВЭРИЙН САЙД**

Т.БАДАМЖУНАЙ

ТӨРӨӨС МАЛЧДЫН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГЫН ЭХНИЙ ҮЕ ШАТ /2009-2015 ОН/-НД
ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

| Бодлогын зорилт | Зорилгыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Хэрэгжүүлэх байгууллага | Үүрдчилсэн тооцоо | | Үүнээс (дав. төг) | | | | | |
|---|--|----------------------------|--------------------------------|------------------------|-------------------|------|------|------|------|------|
| | | | Зарчиг хэмжээ (дав. төг) | Зарчигын санхүүжилт | 2009 | 2010 | 2011 | 2012 | 2013 | 2014 |
| Эрх зүй, эдийн засгийн талтай орчин бүрдүүлэх чиглэлээр | | | | | | | | | | |
| Нэг Малчдыг орон нутгатаа тал тухай амжилдаг, амьдрах нөхцөл бүрдүүлэх, мэдрүүлэх ашигтай байдал, таамаг, кадильер, ийлмийн тээвэр, халгалтын бэлтгэл бий болгоход чилгааран жар зүй, эдийн засаг, бизнесийн таатай орчинг бүрдүүлж, хэрэгжүүлэх арга хэмжээ ашиг | 1. Эрчимжсэн мал аж аюул ариулах болон малчны булаг, хяроо, нахирлал, малчин ариад мал аж аюулыг үйлдэрлэл ариулахад хуралцаж хэмжээний газарыг эзэмшүүлэх талаар хуулийн төсөл боловсруулж хэрэгжүүлэх | ХХААХҮЯ, ЭТБХБЯ | ✓ | ✓ | | | | | | |
| | 2. Эдийн засаг, жэсгөлийн үйлдвэрт тулгуурлан малчдын бэлчээр ашигласныг төлбөрийг олгох арга тогтоож, төлбөрийн тодорхой хэсгийг сумын бэлчээр хамгаалах санд төвлөрүүлэн ашиглах талаар комитет хуульд ношилгоо өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулж хэрэгжүүлэх | | | | | | | | | |
| | 3. Хувь хүний орлогын анбан татвараас малчин ариун чөлөөлөх талаар хуулийн төсөл боловсруулж хэрэгжүүлэх | СЯ, ХХААХҮЯ | ✓ | | | | | | | |



| | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | |
|--|--|--|--|--|--|--|--|--|--|--|--|--|--|--|--|--|--|--|--|--|--|--|--|--|--|--|--|--|--|--|--|--|--|--|--|--|--|--|--|--|--|--|--|--|--|--|--|--|--|--|--|--|--|--|--|--|
| | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | |

| | | Малчдын аж ахуй эрхлэх зохион байгуулалтыг сайжруулах талаар | | | | | | | | |
|--|---|--|--------|---|-------|-------|-------|-------|-------|-------|
| Холбоо, Малчдын өргөмж зорион засгийн үндэс болсон мал аж ахуйн үйлдвэрлэлийн зохион байгуулалтыг сайжруулж бүтээж, човар, ур ашгийг дээшлүүлэх бүтэж дээрүн борлуулж зах зээлийн оноочтой тойролцоо бий болгож | 16. Малчдын амьтан аж ахуй байгуулалд ээл, санхүүгийн дамжлыг үзүүлэх | СН, ХХААХУЯ | 900 0 | Урсдын төсөв | 150 0 | 150 0 | 150 0 | 150 0 | 150 0 | |
| | 17. Малчдын өрх, малчдын бүтэж, хэрцөө, нөхөрлөл нь бизнесийн ХХУЯ, ХХУТ, МЗУГ | ХХААХУЯ, НОХЯ, ХХУТ, МЗУГ | | | | | | | | |
| | 18. Малчдад бизнес, санхүү, зээлийн болон даатгал, хууль зүй, өмгөөллийн үйлчилгээ хүргэхэд дамжлыг үзүүлэх | ХХААХУЯ, ААН | 1008 0 | Урсдын төсөв Гадаадын төсөв, орон нутгийн төсөв | 336 0 | 336 0 | 336 0 | 332 0 | 332 0 | |
| | 19. Орлого багатай малчдыг ажлын байрар хангасан ажил олгогчдыг дамжих | НОХЯ, ХХААХУЯ, ХХУТ, ЖДУГ, МЗУГ | 800 0 | ХЭДС | 200 0 | 200 0 | 200 0 | 200 0 | | |
| | 20. Сум, дүүрэг бурт хэдэн аж ахуйн бүтээгдэхүүн, түүхий эдийг малчдаас авч зах зээлд борлуулан олсон ашгаа малчдад түүвэлдэг хоршооны хэлбэрийг бий болгож, дамжлыг үзүүлэх | СН, ХХААХУЯ | 3000 0 | Урсдын төсөв, ЖДУДС | 500 0 | 500 0 | 500 0 | 500 0 | 500 0 | 500 0 |
| | | | | | | | | | | |



| | | | | | | | | | | |
|--|------------------------|----------|---|-------|-------|-------|---------|---------|---------|---------|
| 21. Малчдын голд ашиг шимт болон цөм сүргийн малад үзэх, ажлалт хийж баталгаажуулах, бүртгэл мэдээллийн санд явах ажил, үйлчилгээ үзүүлэх нөхцөлийг орон нутагт бий болгон хөгжүүлэх | ХХААХҮЯ, МСҮГ | 2000.0 | ГЗЗЗЗЗЗЗ төсөв, АВЗВВВВВ | 500.0 | 500.0 | 500.0 | 500.0 | 500.0 | | |
| | | 4050.0 | Улсын төсөв | 150.0 | 650.0 | 650.0 | 650.0 | 650.0 | 650.0 | 650.0 |
| 22. Малчид, малчдын булж, фермерүүдийн сонирхол, эрх ашгуу нөхцөл төрийн бус байгууллагын үйл ажиллагааг дэмжин хөгжүүлэх | ХХААХҮЯ, НӨХР | 300.0 | Улсын төсөв | 50.0 | 50.0 | 50.0 | 50.0 | 50.0 | 50.0 | |
| | | 900.0 | Гадаадын төсөл, орон нутгийн төсөв | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 200.0 | 200.0 | 200.0 |
| Малчдын нөхцөлийг камгаалах, хөдөлмөр эрхлэлт, эрүүл мэндийн талаар | | | | | | | | | | |
| 23. Малчдыг нөхцөлийг даатгалд хамруулах арга хэмжээ зохион байгуулах | НӨХР, НДЕГ | 132461.1 | Улсын төсөв | | | | 27406.7 | 31973.4 | 36541.0 | 36541.0 |
| 24. Малчдыг эрүүл мэндийн даатгалд хамруулах арга хэмжээг зохион байгуулах | ЭМЯ, НДЕГ | 8640.0 | Улсын төсөв | | | | 2160.0 | 2160.0 | 2160.0 | 2160.0 |
| 25. Малчин байгаль шилжин суурьшсан өргөдийг жижиг эзэлхийн арга хэмжээнд хамруулах замаар аялын байраар хангах | НӨХР, ХХҮТ, МСҮГ | 400.0 | ХЭДС | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | |



| | | | | | | | | | |
|--|--------------------------|--|---|---------|---------|---------|---------|---------|---------|
| 26. Малчид үзүүлэх зүүн мэндийн тусламж, үйлчилгээг сайжруулах төлөвлөгөө | ЗМЯ | 300.0 | Зүүн мэндийг дэмжих сан | 100.0 | 100.0 | 100.0 | | | |
| | | 600.0 | Гадаадын төсөл, хөтөлбөр | 200.0 | 200.0 | 200.0 | | | |
| 27. Малчдыг зүүн мэндийн үзэгдт тогтмол хамруулах арга хэмжээ аяч. "Малчдын зүүн мэнд" хөтөлбөр хэрэгжүүлэх | ЗМЯ | 54000.0 | Улсын төсөв | 10800.0 | 10800.0 | 10800.0 | 10800.0 | 10800.0 | 10800.0 |
| | | Малчдын үйлдвэрлэлийн бүтээмж, чанар, үр ашгийг дэмжих талаар: | | | | | | | |
| 28. Малын зүүн мэнд, уржлийн амил үйлчилгээний хүргэмжийг сайжруулах зорилгоор мал эмнэлэг, уржлийн нэгжийн үйл ажиллагааг дэмжих | ХХААХҮЯ, МЗУТ, ААН | 780.0 | Улсын төсөв Гадаадын тусламж, орон нутгийн засаг | 120.0 | 110.0 | 110.0 | 110.0 | 110.0 | 110.0 |
| | | 780.0 | Улсын төсөв, тусламж, орон нутгийн засаг | 120.0 | 110.0 | 110.0 | 110.0 | 110.0 | 110.0 |
| | | 660.0 | ААН-ийн хөрөнгө | 110.0 | 110.0 | 110.0 | 110.0 | 110.0 | 110.0 |
| 29. Малын чанарыг сайжруулах зорилгоор уржлийн амил, үйлчилгээний нэгжүүдэд нийт бол малын хэрэгжүүлэгчийг шилжүүлэн мэдээлэлт, баталгаажуулалт минсний үндсэн дээр уржлийн амил, үйлчилгээг | ХХААХҮЯ, МЗУТ, ААН | 19200.0 | Улсын төсөв | 6000.0 | 6000.0 | 4800.0 | 2400.0 | | |
| | | 22800.0 | МХС | | | 1200.0 | 3600.0 | 8400.0 | 9600.0 |



| | | Мал аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлт, зах зээлийг нэмэгдүүлэх талаар | | | | | | |
|---|---------------------------|---|-------------|--------|--------|--------|--------|--------|
| 39. Малчдын үүсгэл, санаачилгаар худал гаргах, засварлах, цэв, борооны ус тогтоох, усан сан, нуур, цөөрмийг нийтийг хамарсан ажлын албарээр зохион байгуулахыг төрөөс урамшуулан дэмжих | ХХААХҮЯ, НХХБ, ХХҮТ | 750.0 | ХЭДС | 150.0 | 150.0 | 150.0 | 150.0 | 150.0 |
| 40. Мал болон мал аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн борлуулах нэгдсэн сүлжээ байгуулах | ХХААХҮЯ | 3000.0 | Улсын төсөв | 1500.0 | 500.0 | 500.0 | 500.0 | 500.0 |
| 41. Мал аж ахуйн бүтээгдэхүүний экспортын чөлөөт байдлыг хангах, экологийн цэвэр үндэсний бүтээгдэхүүн үйлдвэрлэх дотоод гаднаад зах зээлд гаргах арга хэмжээг дэмжих | ХХААХҮЯ | 3000.0 | Улсын төсөв | 1500.0 | 500.0 | 500.0 | 500.0 | 500.0 |
| 42. Мал аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнээс орох орлого, бүтээгдэхүүний чанарыг урамшуулах талаар зохион байгуулалтын арга хэрэгсэл дэмжих | СЯ, ХХААХҮЯ | 9000.0 | Улсын төсөв | 1500.0 | 1500.0 | 1500.0 | 1500.0 | 1500.0 |



| | | | | | | | | | |
|---|---------|--------|------------------------------|-------|-------|-------|-------|-------|--|
| 43. Мал, мах болгөл, мал нидлэганы үеийн эрүүл ахуй, ариун цэврийн нөхцөлийг сайжруулж, бүтээгдэхүүний тодорхой болгон нэмүү өртөг шилгэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг бий болгох замаар малчдын орлогыг нэмэгдүүлэхэд чиглэсэн "Мах үйлдвэрлэл" дэд хөтөлбөр хэрэгжүүлэх | ХХААХҮЯ | 900.0 | Улсын төсөв | 300.0 | 300.0 | 100.0 | 100.0 | 100.0 | |
| 44. Сүү, сүүн бүтээгдэхүүний болгөл, тээвэрлэх үеийн эрүүл ахуй, ариун цэврийн нөхцөлийг сайжруулах чиглэлээр "Сүү үйлдвэрлэл" дэд хөтөлбөр хэрэгжүүлэх | ХХААХҮЯ | 2500.0 | Улсын төсөв | 500.0 | 500.0 | 500.0 | 500.0 | 500.0 | |
| 45. Малын гаралтай түүхий эд боловсруулах жижиг, дунд үйлдвэрийг бусуудад илгээж чиглэлээр "Арьс, шир болгөл", "Ноос, ноолуур болгөл" дэд хөтөлбөр хэрэгжүүлэх | ХХААХҮЯ | 3200.0 | Улсын төсөв | 800.0 | 800.0 | 800.0 | 800.0 | 800.0 | |
| | | 1000.0 | Банк, гадаадын зээл, тусламж | 400.0 | 200.0 | 200.0 | 200.0 | 200.0 | |



Малчдын дэв тухай амжилтаж амьдрах нөхцөлийг бүрдүүлэх талаар

| | | | | | | | | | |
|---|--------------------|--------|--|-------|-------|-------|-------|-------|-------|
| 46. Сэрэмжсэн мал аж ахуй эрхэлэгчдэд тохирсон байр, орон сууцны загварыг гаргаж нэвтрүүлэх, орон сууц барилгад дэмжлэг үзүүлэх | ХХААХҮЯ, ЗТБХБЯ | 250.0 | Улсын төсөв | 50.0 | 50.0 | 50.0 | 50.0 | 50.0 | 250.0 |
| | ХХААХҮЯ, ЗТБХБЯ | 1450.0 | Улсын төсөв | | 300.0 | 300.0 | 300.0 | 300.0 | 250.0 |
| 47. "Монгол гэр" хөнгөлбөр хэрэглүүлэн малчдын ажуй нөхцөлийг сайжруулах арга хэмжээ авах | ХХААХҮЯ, ЗТБХБЯ | 1000.0 | ААН-ийн хөрөнгө | 200.0 | 200.0 | 200.0 | 200.0 | 200.0 | 200.0 |
| | ЗБЗХЯ | 1650.0 | Улсын төсөв | 550.0 | 550.0 | 550.0 | 550.0 | 550.0 | |
| 48. Малчин ерх бүрийг радио, цахилгааны эх үүсвэртэй болгох арга хэмжээ авах | ЗБЗХЯ | 1650.0 | Улсын төсөв | 550.0 | 550.0 | 550.0 | 550.0 | 550.0 | |
| | МШХХТТ, ХХААХҮЯ | 300.0 | Бүлэг нийтийн үйлчилгээний үүргийн сан | 50.0 | 50.0 | 50.0 | 50.0 | 50.0 | 50.0 |
| 49. Үүрэн телефоны сүлжээг ашиглан малчдад цаг агаарын урьдчилан сэргийлэх мэдээ болон зах зээлийн мэдээлэл хүргэх, мал аж ахуйн өнөөгийн шатны бүртгэлийн мэдээг малчдаас гар утсаар авч нэгтгэх сүлжээ бий болгох нөхцөлийг бүрдүүлэх | ХХААХҮЯ | 40.0 | ШУТСан | 40.0 | | | | | |
| | ХХААХҮЯ | 40.0 | ШУТСан | 40.0 | | | | | |
| 50. Байгалийн гамшигт үзэгдлийн үед малчид өмсөхөд тохиромжтой дулаан, хөдөлмөр хамгааллын хувцасны үндэсний үйлдвэрлэлийг дэмжих | | | | | | | | | |



| | | | | | | | | | |
|--|-------------------|---------|--------------------------------|-------|-------|-------|--------|--------|--------|
| 55. Малчид, малчин ерх, мал аж ахуйн үйлдвэрлэл, зах ээлийн талаархи мэдээллийн црц сам байгуулан ажиллуулж, малчдыг мэдээллээр хангах | ХХААХҮЯ | 100.0 | Улсын төсөв | | | | 50.0 | 50.0 | |
| | | 200.0 | Гадаадын төсөл, хөтөлбөр | | | | 50.0 | 50.0 | 50.0 |
| Малчдын боловсрол, мэдлэгийг дээшлүүлэх талаар. | | | | | | | | | |
| 56. Малчны байгын сургуулийг орон нутагт байгуулж үйлдвэрлэлд тулгуурласан сургалт зохион байгуулах, "Малчны боловсрол" хөтөлбөр хэрэгжүүлэх | БСШҮЯ, ХХААХҮЯ | 14000.0 | Улсын төсөв | | | | 2800.0 | 2800.0 | 2800.0 |
| | | 7800.0 | Гадаадын төсөл, хөтөлбөр | | | | 1560.0 | 1560.0 | 1560.0 |
| 57. Залуу малчдыг мал аж ахуйн үйлдвэрлэлд дадлагажуулах сургалтын хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх, бизнес инкубаци үйлчилгээ үзүүлэх, "Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих" хөтөлбөр хэрэгжүүлэх | ХХААХҮЯ, НХӨЯ | 3370.0 | ХЗДС | 420.0 | 450.0 | 500.0 | 500.0 | 500.0 | 500.0 |
| | | | | | | | | | |
| 58. Малчдад эзрүүлсэн сонин, сэтгүүл тогтмол гаргаж дэмжих тусгай хөтөлбөрийн дагуу хяналал, мэдээллийн байгууллагатай хамтран ажиллах | ХХААХҮЯ, НХӨЯ | | ААН-ийн хөрөнгө | | | | | | |



ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

ХХААХҮЯ-Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
 НХХЯ-Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам
 ХЗДХЯ-Хууль зүй, дотоод хэргийн яам
 ЗТБХБЯ-Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын яам
 ЭБЭХЯ-Эрдэс баялаг, эрчим хүчний яам
 БСШУЯ-Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам
 ЭМЯ-Эрүүл мэндийн яам
 ОБЕГ-Онцгой байдлын ерөнхий газар
 МЭҮГ-Мал эмнэлэг, үржлийн газар
 СХЗГ-Стандартчилал, хэмжил зүйн газар
 МШХХТГ-Мэдээлэл, шуудан, харилцаа, холбоо, технологийн газар
 УГ-Усны газар
 ААН-Аж ахуйн нэгж
 ХЭДС-Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан
 ШУТСан-Шинжлэх ухаан, технологийн сан
 НДЕГ-Нийгмийн даатгалын ерөнхий газар
 ХХҮГ-Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2009 оны 7 дугаар
сарын 14-ний өдөр

Дугаар 212

Улаанбаатар
хот

Дайнд оролцсон ахмад дайчинд орон сууц олгох тухай

"Дайнд оролцсон ахмад настнуудын талаар авах зарим арга хэмжээний тухай" Ерөнхийлөгчийн 2008 оны 170 дугаар зарлигийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Дайнд оролцсон ахмад дайчинд олгох орон сууцыг 35.0 (гучин таван) сая төгрөгт багтаан шийдвэрлэсүгэй.
2. Дайнд оролцсон ахмад дайчинд орон сууц олгох журмыг баталж, дайнд оролцсон ахмад дайчдад орон сууц олгох ажлыг 2009-2010 онд багтаан зохион байгуулахыг Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Т.Ганди, Батлан хамгаалахын сайд Л.Болд, Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайд Х.Баттулга нарт даалгасугай.
3. Дайнд оролцсон ахмад дайчинд орон сууц олгоход шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг улсын төсөвт тусган санхүүжүүлэхийг Сангийн сайд С.Баярцогтод даалгасугай.
4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Журам батлах тухай"



Засгийн газрын 2008 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 72 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД

С.БАЯР

НИЙГМИЙН ХАМГААЛАЛ,

ХӨДӨЛМӨРИЙН САЙД

Т.ГАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2009 оны 7 дугаар
сарын 14-ний өдөр

Дугаар 213

Улаанбаатар
хот

Улсын төсөвт үйлдвэрийн газар байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 5, Автотээврийн тухай хуулийн 17.3 дахь заалтыг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас **ТОГТООХ** нь:

1. Автотээврийн тухай хуулийн 17.1-д заасан үйл ажиллагааг эрхлэн явуулах чиг үүрэг бүхий "Тээврийн хэрэгслийн оношилгоо, хяналт зохицуулалтын алба" улсын төсөвт үйлдвэрийн газрыг байгуулсугай.

2. "Тээврийн хэрэгслийн оношилгоо, хяналт зохицуулалтын алба" улсын төсөвт үйлдвэрийн газрын дүрмийг нь батлан, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайд Х.Баттулга, Төрийн өмчийн хороо (Д.Сугар)-нд даалгасугай.

3. "Тээврийн хэрэгслийн оношилгоо, хяналт зохицуулалтын алба" улсын төсөвт үйлдвэрийн газрын ажил, үйлчилгээний орлогыг улсын төсөвт бүрэн төвлөрүүлж, үйл ажиллагааны зардлыг улсын төсвөөс санхүүжүүлж байхыг Сангийн сайд С.Баярцогт, Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайд Х.Баттулга нарт даалгасугай.

4. Тухайн орон нутгаас нийслэл болон бусад аймаг, хотын чиглэлд хийх зорчигч тээврийн үйлчилгээг зохицуулах асуудлыг аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэрэгжүүлэгч агентлаг Тээвэр, авто замын газарт шилжүүлж, зохицуулалтын орлогыг тус агентлагт төвлөрүүлэхээр тогтоосугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД

С.БАЯР

ЗАМ, ТЭЭВЭР, БАРИЛГА, ХОТ

БАЙГУУЛАЛТЫН САЙД

Х.БАТТУЛГА

**МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ**

2009 оны 6 дугаар
сарын 24-ний өдөр

Дугаар 23

Улаанбаатар
хот

**ЭРҮҮГИЙН ХУУЛИЙН 28 ДУГААР БҮЛГИЙН ЗАРИМ ЗҮЙЛ,
ЗААЛТЫГ ТАЙЛБАРЛАХ ТУХАЙ**

Албан тушаалын гэмт хэргийн талаар заасан Эрүүгийн хуулийн 28 дугаар бүлгийн зарим зүйл, заалтыг нэг мөр ойлгож, зөв хэрэглэх явдлыг хангах зорилгоор Монгол Улсын Үндсэн хуулийн тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт, Шүүхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.6.5-д заасныг удирдлага болгон Улсын Дээд шүүхээс ТОГТООХ нь:

1. Эрүүгийн хуулийн /цаашид "хуулийн" гэх/ 263 дугаар зүйлийн 263.1-д заасан "албаны эрх мэдэл" гэдгийг сонгуульт болон томилолтын албан тушаалтанд хууль тогтоомжоор олгосон бүрэн эрх, үндсэн чиг үүргийн нэгдэл гэж ойлгоно.

Мөн зүйл, хэсэгт заасан "албан тушаалын байдал" гэж албан тушаалтны хэрэгжүүлж байгаа эрх үүрэгт хамааралгүй боловч тухайн албан тушаалтай холбоотой нэр хүнд, нөлөөг хэлнэ.

Энэ зүйл, хэсэгт заасан албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа "урвуулан ашиглах" гэдгийг Авлигын эсрэг хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-т зааснаар ойлгож хэрэглэнэ.

2. Мөн зүйлийн 263.2-т заасан "хүнд хор уршиг" гэж онц их хэмжээний хохирол учирсан, хүний амь нас хохирсон, хүний бие махбодид хүнд, эсхүл хэд хэдэн хүний биед хүндэтгэр гэмтэл учирсан, байгаль орчны тэнцэл алдагдсан, халдварт өвчин тархсан, аж ахуйн нэгж, байгууллагын хэвийн үйл ажиллагаа алдагдсан, зогссон зэргийг хэлнэ.

3. Хуулийн 264 дүгээр зүйлийн 264.1-д заасан "эрх мэдлээ хэтрүүлэх" гэдгийг Улсын Дээд шүүхийн 2009 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн 16 дугаар тогтоолын 5-д зааснаар ойлгоно.

Энэхүү гэмт үйлдэл нь бусад албан тушаалтны эрх хэмжээнд хамаарах чиг үүргийг хэрэгжүүлэх, онцгой нөхцөлд буюу тусгай зөвшөөрөл авснаар гүйцэтгэх үйл ажиллагааг дур мэдэн явуулах, зөвхөн хамтын зарчмаар шийдвэрлэх асуудлыг дангаар шийдвэрлэх, эсхүл хууль бус бүрэлдэхүүнтэй шийдвэр гаргах зэрэг хэлбэрээр илэрнэ.



Албан тушаалтан албаны эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулах, хэтрүүлэх замаар ашиг хонжоо олсон байдаг хэдий ч бусдын эд хөрөнгийг хууль бусаар, үнэ төлбөргүйгээр өөртөө авах болон бусдын өмчлөлд шилжүүлээгүй байдгаараа өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргээс ялгагдана.

4. Мөн зүйлийн 264.2-т заасан **"хүч хэрэглэж буюу хүч хэрэглэхээр заналхийлж"** гэдгийг Улсын Дээд шүүхийн 2007 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн 41 дүгээр тогтоолын 1.4-т зааснаар ойлгох бөгөөд албан тушаалтан бусдаар дамжуулан хүч хэрэглэсэн буюу хүч хэрэглэхээр заналхийлсэн нь үүнд нэгэн адил хамаарна.

5. Хуулийн 265 дугаар зүйлийн 265.1-д заасан **"Төрийн бус байгууллага"** гэдгийг Төрийн бус байгууллагын тухай хуулийн 4 дүгээр зүйлд, **"аж ахуйн нэгж"** гэдгийг Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.5-д, **"давуу байдал"** гэдгийг Авлигын эсрэг хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4-т, **"ашиг хонжоо"** гэдгийг мөн хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2-т тус тус зааснаар ойлгоно.

6. Хуулийн 266 дугаар зүйлийн 266.1-д заасан **"эрх мэдлээ илтэд хэтрүүлэх"** гэдгийг энэ тогтоолын 3-т зааснаар ойлгож хэрэглэнэ.

7. Хуулийн 267 дугаар зүйлийн 267.1-д заасан **"албан тушаалтны нэр барьж"** гэдгийг төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжид тодорхой албан тушаал эрхэлдэггүй этгээд тухайн байгууллагын албан тушаалтныг хууль бусаар төлөөлснийг ойлгоно.

8. Хуулийн 268 дугаар зүйлийн 268.1-д заасан **"албан үүргийн хувьд гүйцэтгэх үүргээ хэрэгжүүлэхгүй байх"** гэж хууль тогтоомж буюу эрх бүхий байгууллага, албан тушаалтны гаргасан шийдвэр, гэрээний дагуу өөрт нь олгогдсон бүрэн эрх, үндсэн чиг үүргийг санаатайгаар огт биелүүлээгүй буюу зохих ёсоор гүйцэтгээгүй байхыг хэлнэ.

Мөн зүйл, хэсэгт заасан **"гүйцэтгэх ёсгүй үйлдлийг хийх"** гэдгийг албан тушаалтны хувьд өөрт нь олгогдоогүй эрх, үүргийг хэрэгжүүлснийг ойлгоно.

Энэ зүйл, хэсэгт заасан **"хээл хахууль"** гэдэгт хууль бус зорилгоо гүйцэлдүүлэхийн тулд өгсөн эдийн болон эдийн бус баялаг, тэдгээрийг өмчлөх эрх, төлбөргүй буюу хөнгөлөлттэй үзүүлсэн аливаа ажил үйлчилгээ зэргийг хамааруулан үзнэ.

9. Мөн зүйлийн 268.2-т заасан **"хясан боогдуулах"** гэж тухайн хүнд тохиолдсон аливаа шаардлага, тулгамдсан хэрэгцээ, үүссэн нөхцөл байдлыг



ашиглах замаар хээл хахууль зайлшгүй өгөх нөхцөл байдлыг зориудаар бий болгох, эсхүл хээл хахууль өгөхийг тулган шаардахыг хэлнэ.

10. Хуулийн 268¹ дүгээр зүйлийн 268¹.1-д заасан “илт хууль бус эд хөрөнгө” гэдэгт Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4-т зааснаас гадна зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл, түүнчлэн терроризмыг санхүүжүүлэх зорилгоор хуримтлуулсан, бий болгосон эд хөрөнгийг хамааруулан үзнэ.

11. Хуулийн 272 дугаар зүйлийн 272.2-т заасан “хүнд хор уршиг” гэдгийг энэ тогтоолын 2-т зааснаар ойлгоно.

12. Хуулийн 273 дугаар зүйлийн 273.1.1-д заасан “зориулалтын бусаар зарцуулсан” гэдгийг Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.1-14.1.7-д заасан хориглосон үйл ажиллагаа явуулсныг ойлговол зохино.

Мөн зүйлийн 273.1.2-т заасан “зах зээлийн дунджаас дээгүүр үнэ” гэж зах зээлийн эрэлт нийлүүлэлт болон сонгон шалгаруулалтаар тогтсоноос илүү үнэ ханшийг хэлнэ.

Энэ зүйлийн 273.1.5-д заасан “зах зээлийн дунджаас доогуур үнэ” гэдгийг зах зээлийн эрэлт нийлүүлэлтээр тогтсоноос бага үнэ ханш гэж ойлгоно.

Мөн зүйлийн 273.1.6-д заасан “шаардлага хангаагүй” гэж заввал дагаж мөрдвөл зохих, хууль тогтоомж болон олон улсын буюу үндэсний стандартаар тодорхойлсон болзол, шалгуур үзүүлэлтэд нийцээгүй байхыг хэлнэ.

ЕРӨНХИЙ ШҮҮГЧ

С.БАТДЭЛГЭР

ШҮҮГЧ

С.НЯМЖАВ

Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмтгэхлийн редакция


Улаанбаатар-12, Төрийн ордон 128 тоот

И-мэйл: turiin_medeefel@parliament.mn

Утас: 262420, 329612

Хэвлэлийн хуудас 2

Индекс: 14003



Улсын Их Хурлын Тамгын газрын хэвлэх хэсэгт хэвлэв.
Утас 329487